

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-20

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	10-16
2. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	16-18
3. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	18-20

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 19-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ч.Ундрэм, С.Чинзориг, Т.Энхтүвшин;
Тасалсан: Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр.

Нэг. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Монголбанкны Төлбөр тооцооны газрын Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3. Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын

хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.6.Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгө оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.4” гэсний дараа “, 12.6” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.9.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд төвлөрүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 1/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшинэ. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

“9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 8
Бүгд: 10
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

5.8.Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчит, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувьцаа, Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Байнгын хорооны танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналын томъёололтой холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулав.

1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн талаар:

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2.Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн талаар:

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, “Ажил олгогчдын нэгдсэн холбоо”-ны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,**

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, гишүүдээс бүрдэнэ.

10.2. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, дэд зөвлөлийн нийтлэг дүрэм, тэдгээрийн эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3. Мэргэжлийн нэгдсэн холбооны дэргэд тухайн салбарын онцлогоос хамаарсан үйл ажиллагаа, мэргэжлийн чиглэлээр дагнасан дэд зөвлөл ажиллаж болно. Дэд зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, дүрмийг удирдах зөвлөлийн хурлаар батална.

10.4. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад албан тушаалтан энэ хуулийн 12.1.10-т заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн, тухайн салбарын болон мэргэжлийн эрх ашгийг хөндсөн, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан бол хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тухайн албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

10.5. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах ажлын албатай байж болно.

10.6. Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.7. Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.8. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024.02.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, мөн газрын Зөвшөөрлийн хэлтсийн захирал Ш.Хандсүрэн, Хяналт шалгалтын газрын захирал Ц.Нарандалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Илтгэл болон төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хуралдааны ирц хүрэхгүй болсон тул хуралдааныг өндөрлүүлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим,
11 цаг 39 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Дамбын Батлут гишүүн орон нутагт ажиллаж байна. Чинбатын Ундрам гишүүн орон нутагт ажиллаж байна. Содномын Чинзориг гишүүн орон нутагт ажиллаж байна. Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн орон нутагт ажиллаж байна. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55,6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 04 сарын 19-ний хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байна.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Засгийн газар 2024 оны 04 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг,

2. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019 оны 02 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг,

3. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2024 оны 02 сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх гэсэн 3 асуудлыг Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл шийдвэрлэсэн.

Ингээд хэлэлцэх асуудал дээр асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Засгийн газраас 2024 оны 04 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 24 оны 04 сарын 18-ны өдрийн нэгдсэн чуулганаа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан

даргалагчаас гүйцээн боловсруулахаар чиглэл өгсний дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн 13 дахь хэсгийг Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүүд тооцох, эс үгүй бол бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй санхүү хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах агуулгаар өөрчлөн найруулах саналыг бэлтгэлээ.

Мөн төслийн 12.6 дахь хэсгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгөөр оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангах агуулгаар өөрчилж, найруулж, мөн үүнтэй холбогдуулан төслийн 12.8 дахь хэсэгт өөрчлөлт оруулах, 10.9 дэх хэсэгт өөрчлөлт оруулах, найруулах санал бэлтгэсэн байна.

Ажлын хэсэг хуралдаан хуралдаан даргалагчийн гүйцээн боловсруулах чиглэл өгсөн Ажлын хэсгээс анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн 4.1,5, 12.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах саналаа татаж, төслийн заалтыг хэвээр үлдээхээр санал хурааж шийдвэрлэсэн болно. Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй холбогдуулан хуралдаан даргалагчийн гүйцээн боловсруулах чиглэл өгсөн Ашигт малтмалын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэл хувийг, 5.5 дахь заалтыг нь улсын төсвийн

оролцоогүйгээр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон бол 34 хүртэл хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшихээр өөрчилсөн болно.

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгээс анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг эцсийн хэлэлцүүлэгт дахин хураалгахаар бэлтгэсэн болно. Мөн хуулийн 5.7, 5.8 дахь хэсгийг өөрчлөн найруулах саналын томьёолол бэлтгэлээ.

Анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрөөтэй саналын томьёололтой холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төв банк, Төв банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрөөтэй саналын томьёолол, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүнд баярлалаа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулъя. Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мэндбаяр УУХЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга, Баярмандал АМГТГ-ын дарга, Батмагнай Ашигт малтмал газрын тосны Кадастрын хэлтсийн дарга, Батсайхан Монголбанкны төлбөр тооцооны газрын Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал, Тулга Сангийн яамны

Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Агиймаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналуудаар санал хураалт явуулъя. Саналын томъёолол.

1. Төслийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.3.Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкн дахь төрийн сангийн дансанд байршуулна. Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцох, эсхүл бодлогын хүүгээс багагүй өгөөжтэй, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулна.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар. Цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалт.

Гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.6.Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын болон өөрийн хөрөнгө оруулсан авто зам, төмөр зам, дэд бүтцийн төрийн өмчит, төрийн өмчийн

оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж, удирдлага зохион байгуулалтаар хангана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 80 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3. Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.4” гэсний дараа “, 12.6” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4. Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.9.Энэ хуулийн 12.4, 12.6-д заасан хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдэд төвлөрүүлнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 1/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй

хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5. Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмших бөгөөд төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал гишүүдийн 60 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 3/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

“9.1.5. Энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их

Хуралд өргөн мэдүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Миний энэ уучлаарай, миний төхөөрөмж ажилласангүй. Ийм учраас саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэн тул саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд санал хураалт дахин явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Ганхуяг гишүүн үгээ хэлье.

Х.Ганхуяг: Энэ дээр нэг асуудал байгаа юм. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дата бааз дээр бол угаасаа эцсийн өмчлөгч бол харагддаггүй юм. Яах вэ, Монгол Улсын иргэн бол харагдах байх. Тэгээд эцсийн өмчлөгчийн бас бүртгэл бас төдийлөн хийгддэггүй. Тэгээд энэ дээр бол нэг цоорхой нь юу байна гэхээр одоо байгаа этгээдүүд оффшор компани байгуулаад тэгээд энэ 34 биш 100 хүртэл эзэмших боломжтой байдлаар ингээд бичигдчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр бол шууд болон шууд бусаар гэдэг үгийг оруулахгүй бол энэ чинь ингээд хэдэн ч оффшор компани байгуулж болно шүү дээ. Тэгээд тэр нь харагдахгүй, мэдэгдэхгүй.

Тэгэхээр тухайн тэр эзэмшиж байгаа компаниудынхаа эцсийн өмчлөгчийн мэдээллийг нь авдаг байж байж энэ асуудлыг ярьдаг байхгүй бол ингээд явчих юм бол зүгээр л энэ чинь нэг уриа лоозонгийн шинж чанартай л болчих гээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ ажлын хэсэг дээр уг нь хэлж байсан юм. Тэгээд аваагүй л байна л даа, үүнийг.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Үүнийг 20 байсныг нь 34 болгохдоо анх өргөн барихдаа 20 байсан шүү дээ. Тэгээд 34 болгохдоо бид, манай яам саналыг боловсруулахдаа яг тэр Ганхуяг гишүүний хэлж байгаа шууд болон шууд бусаар гэдэг үг байсан. Тэгээд би бас түрүүн хэн Мийгаа зөвлөхөд бас үүнийг хэлээд байгаа байхгүй юу. Шууд болон шууд бусаар гэдгийг манай яамныхан бас ингээд хэлээд байх юм.

Тэгэхээр үүнийг ингээд оруулахгүй бол болохгүй байна. Тэгээд анх нөгөө өргөн баригдахдаа байсан шууд болон шууд бусыг нь нөгөө хэн Занданшатар дарга хасчихсан юм уу. Яачихсан юм. Үгүй ээ, үгүй, энэ үгүй ээ, үгүй дарга аа, гүйцээн боловсруулах дээр 3-ны 2 бол хамаагүй л дээ, тийм биз дээ. Яачихсан юм, 3-ны 2 хамааралгүй л дээ, энэ чинь олонхоороо л шийдэх ёстой. Хэрвээ гишүүн, дарга аа, хар аа, үгүй ээ зүгээр гүйцээн боловсруулж байгаа нөхцөлд бол хамааралгүй л байх л даа.

Ц.Цэрэнпунцаг: Санал хураалт. Санал хураалт.

Саяын санал хураалтад тэгээд яасан юм. Хэн, горимын санал гаргаадхаач, сая уначихсан шүү дээ. Доржханд гишүүний микрофоныг нээе. Горимын санал гаргая.

Т.Доржханд: Дарга аа, төхөөрөмж ажилласангүй. Саяын

саналыг хүчингүйд тооцоод дахиад санал хурааж өгнө үү. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Санал хураалт. Саяын би уншсан шүү, би үүнийг оруулж уншаагүй шүү. Саяын тэр шууд бус зүйл шууд, саяын орж ирснийг би уншаагүй шүү. Минийх ажилласангүй. Өнөрболор гишүүн дахиад горимын санал гаргах уу.

Д.Өнөрболор: Сая миний төхөөрөмж ажилласангүй дарга аа, дахиж санал хураалгаж өгөөч. Энэ саналыг хүчингүйд болгоод.

Ц.Цэрэнпунцаг: Өнөрболор гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас саяын хураасан санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, саяын хураагдсан санал хүчингүй болсон тул санал хураалтын би томъёоллыг уншъя. Тэгээд санал хураалтаа явуулъя.

3. Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно”. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4. Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

5.8.Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувьцаа, Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын

гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр уншиж танилцуулна.

Чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналын томъёоллуудтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг баримтлан боловсруулсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг та бүхэнд тараасан тул нэг бүрчлэн унших шаардлагагүй байх.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар гишүүдээс санал гараагүй бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт батлах шаардлагатай

байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

2. Хамт өргөн мэдүүлсэн хууль тийм ээ. Дагаж боловсруулж байгаа тухай хуулийн 2. 2 дахь хууль. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар гишүүдээс санал гараагүй бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт батлах шаардлагатай тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Баттөмөр гишүүн, таны саналын эсрэг гарсан байна. Горимын санал

гаргах уу? Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Би энэ саналыг дэмжсэн юм. Тэгээд энэ аппарат ажиллахгүй байна. Ер нь Тамгын газрын энэ аппаратынхаа бүрэн бүтэн байдлын тэр үзлэг хийхгүй бол ерөөсөө болохгүй, ажиллахгүй байна шүү дээ. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Цэрэнпунцаг: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн Баттөмөр гишүүний саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, саяын санал хураалт хүчингүй болсон тул санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

3. Төв банк Монголбанкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар гишүүдээс санал гараагүй бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлтэй хамт батлах шаардлагатай байгаа тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь заалтыг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн горимын

санал гаргаж байна. Санал хураалт явуулъя.

Гишүүдийн 60 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монголбанкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Баттөмөр танилцуулна.

12.09 цаг

Хэлэлцэх асуудал 2.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл ба хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулна. Гишүүний микрофоныг нээнэ үү.

Б.Баттөмөр: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Учралаас 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 04 сарын 18-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг 2024 оны 4 сарын 19-ний өдрийн хуралдаанаараа төслийн эцсийн хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, эцсийн хувилбарын төслийг бэлтгэн хэлэлцүүлээ.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үеэр хуралдаан даргалагчаас ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр төслийн 10 дугаар зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгч, Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу төслийн 10 дугаар зүйлийг дахин томъёолон санал хураалт явуулахад ажлын хэсгийн олонх дэмжлээ.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Хуягийн Ганбаатар Ажил олгогчийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал.

Ажлын хэсгийн нэрсийг танилцууллаа. Ингээд ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналаар санал хураалт явуулъя.

1 санал хураалт явагдана. Нэлээн урт санал байна.

1. Төсөлд доор дурдсан агуулгатай 10 дугаар зүйл бүхий Гуравдугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ
МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГИШҮҮНЧЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ**

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

10.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь ерөнхийлөгч, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, гишүүдээс бүрдэнэ.

10.2. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгчийн бүрэн эрх, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ажлын алба, дэд зөвлөлийн нийтлэг дүрэм, тэдгээрийн эрх зүйн байдал, гишүүдийн эрх, үүрэг, бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах, саналын эрхийг тогтоох, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад харилцааг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

10.3. Мэргэжлийн нэгдсэн холбооны дэргэд тухайн салбарын онцлогоос хамаарсан үйл ажиллагаа, мэргэжлийн чиглэлээр дагнасан дэд зөвлөл ажиллаж болно. Дэд зөвлөлийн

бүтэц, зохион байгуулалт, дүрмийг удирдах зөвлөлийн хурлаар батална.

10.4. Мэргэжлийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүд болон бусад албан тушаалтан энэ хуулийн 12.1.10-т заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн, тухайн салбарын болон мэргэжлийн эрх ашгийг хөндсөн, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан бол хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тухайн албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

10.5. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах ажлын албатай байж болно.

10.6. Мэргэжлийн нэгдсэн холбоо орон нутаг болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

10.7. Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

10.8. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь өөрийн нэр дээр банкны данстай байна.”

Би сая саналын томъёоллыг уншсан. Ингээд санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд. Цаашид “ажлын хэсэг” гэх.

Анхааралтай байгаарай, гишүүд ээ. Санал хураалт гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт.

Гишүүдийн 60 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр уншиж танилцуулна.

12.18 цаг

Дараагийн асуудалдаа оролц оръё. Хэлэлцэх асуудал 3.

Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны бүрэн эрхийнхээ дагуу Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар системд нөлөө бүхий банкнуудын нээлттэй ХК-ийн хэлбэрээр зохион байгуулах шаардлагыг тогтоосон бөгөөд үүний дагуу Хаан, Худалдаа хөгжил, Голомт, Хас, Төрийн банкнуудаас анх удаагаа хувьцаагаа олон нийтэд санал болгон хөрөнгийн зах зээл дээр амжилттай гаргаж, хуулийн шаардлагыг биелүүлсэн.

Дээрх хуульд зааснаар банкны хувь эзэмшигчдийн төвлөрлийг 23 оны 12 дугаар сарын 30-ны дотор 20 хувь хүртэл бууруулах үйл явц нь олон улсын хөрөнгийн зах зээл боломжит хөрөнгө оруулахаас хамааралтай байгаа банкнуудын хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг хуульд заасан хугацаанд бууруулах боломж гарсангүй. Ийм учраас 21 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн “2023 онд” гэснийг “2026 онд” гэж өөрчилсүгэй гэсэн ийм хуулийн төслийг өргөн мэдүүлж байгаа юм. Хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя.

Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч, Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Ариунбат Монголбанкны Бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал, Нарандалай Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал, Хандсүрэн Монголбанкны Бүтцийн өөрчлөлт бодлогын газрын Зөвшөөрлийн хэлтсийн захирал.

Хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ганхуяг гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Номхон тэмээ ноолоход амар гэгчээр Баттөмөр гишүүнээр ер нь нэг ийм жсоохон хуулийн хулгай хийх санаа бүхий хуулиуд их орж ирж байна. Банкны хууль бол 2021 оны 01 сарын 21-нд батлагдсан. Энэ хуулиар 3 том өөрчлөлт хийгдэх ёстой байсан.

1 дүгээрт бол олон нийтийн болох,

2 дугаарт, 20 хүртэл хувийг хувьцааг нь задлах,

3 дугаарт, банк, банкнаас бусад төрлийн бүх үйл ажиллагааг хориглох гэсэн ийм 3 заалттай юм. Энэ дотроос бол системийн 5 банк бол нээлттэй болох нь бол болсон. Нөгөө 2 хуулийн заалт бол хэрэгжихгүй байгаа. Үүнийг бол их шаардсан.

Тэгээд яагаад энэ хэрэгжилтийн хугацааг нь 23 оны 12 сарын 31 гэж тавьсан бэ гэхээр энэ Их Хурлын циклийн хугацаа нь дуусах зорилгоор тавьсан. 2021 оны 01 сарын 21-нд энэ хуулийг батлагдах гэж байхад ажлын хэсгийн гишүүд рүү чиглэсэн пи ар акц явсан. Талбай дээр миний зургийг хүртэл шатаасан. Жагсаал хийсэн. Та бүхэн Монголбанкныхан нь бол сайн мэдэж байгаа даа.

Энэ хууль батлагдах болсон шалтгаан юу вэ гэхээр 2020 онд зарим нэг банк, зарим нэг бүлэглэл, 49 хувь, Дархан, Хөтөл, Цемент, Төмөр зам гээд бүх хулгайг хийсэн байхгүй юу. Үүний эсрэг гарсан хууль байхгүй юу. Тэрнийхээ төлөө би 3 жил, 4 жил хэвлэлээр нүдүүлж байна. Хөгжлийн банкны хулгайч гэж дуудагдаж байна. Шүүхээр хүртэл явлаа. Хулгайч биш гэдгээ нотоллоо, хамааралгүй гэдгээ нотоллоо. Тэгээд өнөөдөр яг Их Хурал яахын өмнө энэ хуулийг оруулж ирж байгаа байхгүй юу. Дараагийн Их Хурлын үед энэ хууль явахгүй, 34, 20 хувь гэдэг чинь ч байхгүй болно. Энэ хууль дахиад л шинэчлэн найруулагдаад л энэ ярьж байгаа энэ банкны энэ хулгай чинь үргэлжлээд л явна. Ичээрэй та нар.

12 сарын 31-нд энэ хууль хэрэгжээгүй байвал та нар энэ арилжааны банкнууд дээр БЭТ томилох ёстой байсан. Хуулиараа. Хуулийг хэрэгжүүлэх та нар үүрэгтэй болохоос биш ингээд толгойг нь илээд яваад байж болохгүй байхгүй юу. Тэгээд зориг гаргаад энэ хуулийг нь батлуулдаг, монополийг нь задлах гэж оролддог, эцсийн хохирогч нь хэн бэ гэхээр ард түмэн байхгүй юу. Өнөөдөр яагаад

зээлийн хүү 18, 20 хувийн хүүтэй байгаа юм. Өнөөдөр яагаад Монголбанк дээр арилжааны банкнуудын 10 их наяд төгрөг хадгалагдаад байгаа юм. Ямар ч эрсдэлгүйгээр. Яагаад хувийн хэвшилд зээл нь очихгүй байгаа юм. Дөнгөж сая Баялгийн сангийн юун дээр оффшорчдын заалтыг оруулчихлаа. Одоо ингээд дахиад Банкны хуулийн энэ хэрэгжилтийг нь хойшлуулах юм орж ирж байгаа байхгүй юу. Ажлаа хийж чадахгүй бол ажлаа өгч сурах хэрэгтэй та нар. Та нар ард түмний төлөө ажиллаж байгаа болохоос биш өөрсдийнхөө төлөө ажиллаагүй шүү. Төрийн алба бол хугацаатай байдаг юм. Хуулиа хэрэгжүүлж чадахгүй бол зайлцаа, наанаасаа.

Ц.Цэрэнпунцаг: Би тайлбар хэлээдэхье. Ганхуяг гишүүн ээ, энэ саяын 3 дурдсан хууль байна шүү дээ, Улсын Их Хурлын гишүүний, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан. Байнгын хорооноос аль ч энэ захирамж гаргаагүй. Энэ ажлын хэсгийг байгуулахад үүрэг чиглэл өгөөгүй байна. Мэргэжлийн нэгдсэн холбоо бас Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан. Баялгийн сангийн хууль Засгийн газраас өргөн мэдүүлж энэ ажлын хэсгийг Их Хурал дээр байгуулахдаа мөн Их Хурлын даргын захирамжаар байгуулсан.

3 дахь Банкны холбоотой хууль бол энэ хуулийг хугацаа сунгах гарцаагүй шаардлага тулсан байсан. Ингээд гишүүн өөрөө санаачилж, бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилсан.

Ер нь ингээд нэг энд нэг зүйлийг хэлчихье. Гишүүд энэ гишүүд энэ хавар ингээд хуралдаа суугаагүй гишүүд ажлын хэсэгт орно, саналаа өгнө, чөлөөтэй нээгээд Баялгийн сангийн хууль дээр бол Ганхуяг гишүүнийг сая ажлын хэсэгт оруулсан. Ажлынхаа хэсэгт хуралд суухгүй, гадаа дотор алга болсон.

Дээрээс нь хуралд суудаг яг гишүүд гээд ингэх юм бол Баттөмөр гишүүн энэ нэг ч өдөр энэ саарал ордонд бөгс өндийлгөхгүй сууж, энэ олон хуулийн ард энэ ачаалал дор ажиллалаа. Тэгээд энэ бас ажил хийж байгаа энэ гишүүд рүүгээ ингэж дайрдаг ийм зохимжгүй байдал бол энэ сонгууль ойртсонтой холбоотой юм уу гаргаж болохгүй. Ийм ёс зүйгүй үйлдэл гаргаж болохгүй гэж би бодож байна.

Тэгээд энэ саяын энэ асуудлуудыг ингээд хүн гүжирдээд, тэгээд энэ ажил хийж байгаа гишүүд рүү, нөхөд рүүгээ ингэж дайрчхаад ингээд хаяад гараад явдаг бол зохимжгүй байна шүү. Ер нь цаашидаа ийм үйлдэл гаргахгүй байвал бас ард түмэн бас зөв талаас нь ойлгох байлгүй дээ.

Ингээд санал хураалт.

Өнөөдрийн энэ Байнгын хорооны ирц санал хураалт тийм, хүрэхгүй болсон тул өнөөдрийн 3-д хэлэлцэх асуудал болохгүй.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг ирэх 7 хоногт, дараагийн 7 хоногийн хуваарьт оруулъя.

Ингээд өнөөдрийн энэ Байнгын хорооны хурлаа үүгээр өндөрлөе.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ